



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 19 өдөр

Дугаар A/13

Эрдэнэт

Г Улсын онцгой комиссын шийдвэрийг Г  
хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.1.5./в/, 29.1.6./л/, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.2.3, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалт, Улсын онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2020 оны 238 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

1.1. Баян-Өндөр, Жаргалант сумдын хэмжээнд зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүд архи согтууруулах ундааг өглөөний 10.00 цагаас оройн 18.00 цаг хүртэл худалдан борлуулахыг зөвшөөрсөн хугацааг 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийг дуустал сунгасугай.

1.2 Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд архи согтууруулах ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа (рестораны архи согтууруулах ундааны үйлчилгээ, баар, караоке, паб)-г түр зогсоосон хугацааг 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийг дуустал сунгасугай.

1.3 Мөн олон нийтийг хамарсан үйл ажиллагаа (хичээл, цугларалт, сүм хийдийн хурал, үзвэр, хонжвор, РС тоглоом, уралдаан тэмцээн)-г түр зогсоосон хугацааг 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийг дуустал сунгасугай.

1.4 Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн төгсөх ангийн сурагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг 1 хичээлийн танхимд 10 сурагчтайгаар халдвар хамгааллын дэглэмийг баримтлан тодорхой цагийн хуваарьтайгаар зохион байгуулахыг тус тус зөвшөөрсүгэй.

1.5 Нэг удаа 12 хүнээс хэтрүүлэхгүйгээр спорт зааланд тоглох болон 1 удаа 10 хүн буюу 1 хүнд 4м/кв талбай ноогдохоор тооцож секц, дугуйлан, сургалт, хэлэлцүүлэг,

D:(Zahiramj) A-4 doc  
**J220210096**

семинар, курс, саун, дамжаа, фитнес, спиннингээр хичээллэх үйл ажиллагааг өглөө 10.00 цагаас орой 20.00 цагийн хооронд зохион байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Дээрх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (А.Бумансор), Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Боловсрол, соёл урлагийн газар (О.Ариунгэрэлт), Биеийн тамир, спортын газар (Д.Дэлгэрбаяр), “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ” (Х.Бадамсүрэн), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт үүрэг болгосугай.

3. Орхон аймаг, Эрдэнэт хот руу орж гарч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тавих мэргэжлийн байгууллагуудын хяналт, ажлын зохион байгуулалтыг сайжруулж, хөдөлгөөнт эргүүл гаргах, албан ёсны хяналтын постоор орж ирээгүй зөрчил гаргасан тээврийн хэрэгслийг журамлах, жолооч, зорчигчдод холбогдох хариуцлага тооцох, тусгаарлах ажлыг хэрэгжүүлж хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Тагнуулын газар (О.Мөнхчулуун), Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Бат-Өлзий), Мал эмнэлгийн газар (П.Эрдэнэжаргал), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр) нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүй дэмжлэгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, аймгийн Засаг даргын Хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч М.Түмэнжаргал, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  С.БАТЖАРГАЛ